



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/106

Мандалговь

Г Гэрээ байгуулах тухай Г


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.1 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны А/39 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хуучин амбулаторын барилгын засвар”-ын ажил /ЭМСЯ/201701018/-ын гүйцэтгэгчээр “Тэргэн нүүр” ХХК – ийг сонгон 89,271,548 /наян есөн сая хоёр зуун далан нэгэн мянга таван зуун дөчин найман/ төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу барилгын засварын ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг “Тэргэн нүүр” ХХК-ний гүйцэтгэх захирал /Б.Баярсайхан/ -д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Н.Эрдэнэ-Очир/, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга /Х.Жаргал/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА О.ЧУЛУУНБАТ



0200281